




Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (JICA)



“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”

Төслийн мэдээлэл
2013 оны 2 дугаар сар №6

“БАГШЛАХУЙН АРГА ЗҮЙН ХӨГЖЛИЙГ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ БҮСЧИЛСЭН СУРГАЛТ”

2012 оны 11 сард “Багшлахуйн арга зүйн шинэчлэлийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүсчилсэн сургалт”-ыг Нийслэлийн СХД, БЗД болон Завхан, Булган, Сэлэнгэ, Дорнод аймгуудад зохион байгууллаа. Үндэсний хэмжээнд багшлахуйн арга зүйн шинэчлэхэд багш бэлтгэдэг их дээд сургуулиудын үүрэг оролцоо чухал бөгөөд өнгөрсөн оны мөн адил орон нутгийн багш бэлтгэдэг их дээд сургуулиудын төлөөллийг уг сургалтад хамруулсан юм.

Энэхүү сургалтын зорилго нь 4 өдрийн туршид суралцахуйд суурилсан багшлах арга зүйг бүх аймаг, дүүргүүдэд түгээн дэлгэрүүлэх ажлыг гардан гүйцэтгэх сургагч багш нарыг бэлтгэх явдал байсан бөгөөд мэргэжлийн баг болон төслийн загвар аймаг, дүүргийн багийн гишүүд сургагч багшаар ажилласан.

Сургалтын эхний өдөр, нийт оролцогчдод суралцахуйд суурилсан багшлах арга зүй болон бусад улс орон дахь багшлахуйн арга зүйн шинэчлэлийн талаар танилцуулах зорилго бүхий (Япон болон Индонезийн сургалтад оролцсон багш нарын тайлан) лекц зохион байгуулсан. Мөн, төслийн загвар сургуулиудын хичээлийн судалгаа болон мониторингийн үр дүнгийн талаар тайлагнасан.

2 дахь өдрөөс эхлэн оролцогчид 8 судлагдахууны багт хуваагдан ажиллаж, өмнөх жилийнхээс засан сайжруулсан сургалтын модуль ашиглан хичээлийн бэлтгэл судалгааны тухай ойлголтоо гүнзгийрүүлэн, дараа өдрийн судалгаат хичээлийн бэлтгэл, хичээл ажиглалт хэлэлцүүлгийн зорилго, зохион байгуулах аргачлал зэргээ тодорхойлсон.

3 дахь өдөр судлагдахуун бүрээр судалгаат хичээл, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Сургалтын сүүлийн өдөр оролцогчид байгууллага орон нутгийн багаараа хуваагдан дадлага ажил, судалгаат хичээлээр дамжуулан сурч мэдсэн зүйл болон тулгамдсан асуудлаа бусадтайгаа хуваалцаж,

цаашид байгууллага орон нутгийн түвшинд багшлахуйн арга зүйн шинэчлэлийг хэрхэн түгээн дэлгэрүүлэх тухай үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан.

Төслийн баг өдөр бүр мониторингийн асуулга судалгаа авч, сургалтын талаархи оролцогчдын сэтгэл ханамж болон сурч мэдсэн зүйлийг тандах, өдөр бүрийн сургагч багш нарын багийн хурлын үед дараа өдрийнхөө үйл ажиллагаанд тусгахыг санал болгон зөвлөх зэргээр идэвхитэй ажилласан.

Төслийн аливаа сургалтыг БСГ, мөн сургалтын байраар хангасан сургуулийн захирал, сургалтын менежер, багш нар болон бусад олон хүн халуунаар дэмжин ажиллаж ирсэн бөгөөд энэ удаагийн бүсчилсэн сургалт ч амжилттай болж өнгөрлөө.

Физикийн судалгаат хичээл дээр сурагчид туршилт хийж буй байдал /Завхан аймаг/



Хүн орчин судалгаат хичээл/ Булган аймаг/



Төслийн тухай товчхон

Монгол Улсын боловсролын салбарт 2005 оноос цогц чадамжид суурилсан бага, дунд боловсролын стандарт, 2008 оноос Сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Эдгээр шинэ стандарт, хөтөлбөрт сурагчдын өөрсдөө мэдлэг бүтээх чадварыг хөгжүүлэх, улмаар багш бүр сургалтын шинэ арга зүйг эзэмших явдал зайлшгүй чухлаар тавигдаж байна.

Иймд БСШУЯ болон ЖАЙКА хамтран 2010 оны 4 сараас “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.

Төслийн зорилго нь “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил (2006-2009)” төслийн хүрээнд боловсруулсан багшид зориулсан зөвлөмж, эдүгээ боловсруулж буй сургалтын модулийг ашиглан сургалт зохион байгуулж, суралцахуйд суурилсан багшлах арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүтэц, тогтолцоог бэхжүүлэх явдал юм.

Тус төслийг МУИС, МУБИС, Боловсролын хүрээлэн болон төслийн 1 дэх шатанд оролцсон хүмүүсээс бүрдсэн “Мэргэжлийн баг” загвар аймаг, дүүргээр сонгогдсон СХД болон Булган, Завхан аймгуудтай хамтран хэрэгжүүлж байна.

Гарчиг:

Багшлахуйн арга зүйн хөгжлийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүсчилсэн сургалт	1
Төслийн тухай товчхон	1
Хичээлийн судалгааны олон улсын бага хурал (WALS 2012)	2
Сургуулийн удирдлагад зориулсан Сэлэнгэ аймгийн БСГ-ын сургалт	2
Бага ангийн математик, Байгалийн ухааны хэлэлцүүлэг сургалт	3
Эцсийн төлөв байдлын судалгаа	4
Төслийг 6 сарын хугацаагаар сунгав	4

ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛ (WALS 2012)

“Хичээлийн судалгааны дэлхийн нийгэмлэг (WALS: World Association of Lesson Studies)” -ийн та хэр зэрэг мэдэх вэ? WALS нь багшлахуй болон суралцахуйн чанарыг дээшлүүлэх тулд хичээлийн судалгааны судалгаа шинжилгээ, хэрэгжилтийг хөхүүлэн дэмжих, хөгжүүлэх зорилгоор байгуулагдсан нийгэмлэг юм. Жилд нэг удаа өргөн цар хүрээ хамарсан олон улсын хурал зохион байгуулах бөгөөд янз бүрийн орны боловсролын салбарынхан нэг дор хуран чуулж, хичээлийн судалгааны туршлага, хэрэгжилт, учирч буй тулгамдсан асуудлуудын талаар илтгэл тавин санал бодлоо солилцдог байна.

2012 оны 11 сарын 28-30-нд Сингапурт зохион байгуулагдсан 8 дахь удаагийн Олон улсын бага хуралд Монгол улсаас анх удаа Ч.Нямгэрэл багш (МУИС-ийн ХХИС-ийн багш, Химийн мэргэжлийн багийн ахлагч) оролцож, Ж.Энэбиш багшийн (БГД-ийн 113-р сургуулийн багш асан, эдүгээ БМДИ-ийн арга зүйч) зохион байгуулсан хичээлийн судалгааны хэрэгжилтийн талаар илтгэл тавилаа. Түүний илтгэл нь атом сэдвээр зохион байгуулсан нийт 10 цагийн нэгж хичээлээр жишээ татан, уг хичээлийг заасан багшийн хөтөлбөр боловсруулсан технологи, хамт ажилладаг багш нарын хичээл ажиглах чадварыг эхний цагийн хичээл болон 9-10 дахь цагийн хичээлтэй харьцуулан дүн шинжилгээ хийсэн судалгаа байв.

Ч.Нямгэрэл багш Сингапураас эргэж ирснийхээ дараа буюу 2012 оны 12 сарын 7-ны өдөр УБ дахь Багшийн хөгжлийн ордон дээр олон улсын хуралд оролцсон тухайгаа тайлагнах үедээ Монгол дахь хичээлийн судалгааны хэрэгжилт ба бусад улс орон дахь хэрэгжилтэд дараахи төсөөтэй болон ялгаатай талууд байгаа тухай дурьдсан.

Хичээлийн судалгааны олон улсын бага хурлын сурталчилгааны самбарын өмнө

Гол төсөөтэй талууд:

- Хичээлийн судалгааны хэрэгжүүлэхэд сургууль, багш нарт тулгарч буй тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам
- Сургуулиудын хичээлийн судалгааны хэрэгжилтэд удирдлагын үүрэг оролцоо чухал болох
- Сурагчдын идэвхи санаачлагыг дээшлүүлэх явдал чухал болох
- Багш нарын ур чадвараа дээшлүүлэх хэрэгцээ шаардлага байгаа болох

Гол ялгаатай талууд:

- Зарим улс орон хичээлийн судалгааны үр дүн сурагчдын суралцах чадварт хэрхэн нөлөөлж буй тухай судалгаа шинжилгээ хийдэг.
- Зарим улс оронд судалгааны байгууллага ба сургуулиуд албан ёсоор хамтарч ажилладаг.
- Зарим улс орон хичээлийн судалгааг эрдэм шинжилгээний ажлын түвшинд авч үздэг.



Цаашид, Монголд хичээлийн судалгааг боловсронгуй болгоход янз бүрийн түвшинд холбогдох байгууллагуудын уялдаа холбоо чухлаар тавигдана. Мөн, WALS зэрэг олон улсын хуралд Монгол дахь хэрэгжилтийн талаар таниулан сурталчлах, дотооддоо хичээлийн судалгааны туршлага солилцох эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах явдал ч тун чухал.

СУРГУУЛИЙН УДИРДЛАГАД ЗОРИУЛСАН СЭЛЭНГЭ АЙМГИЙН БСГ-ЫН СУРГАЛТ

2013 оны 1 сарын 15-16-нд, Сэлэнгэ аймгийн 1-р сургууль дээр Сэлэнгэ, Орхон, Дорноговь аймгийн ЕБС-ийн удирдлага болох 70 орчим оролцогчтой 2 хоногийн сургалт зохион байгуулагдлаа. Уг сургалтыг, төслийн хүрээнд 2012 оны 11 сард зохион байгуулсан “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үндэсний хэмжээний бүсчилсэн сургалт”-ад оролцогчдын “Арга зүйн шинэчлэлийг хэвшүүлэхэд сургуулийн удирдлагын суралцахуйд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгааны талаархи ойлголт чухал” гэсэн саналд үндэслэн зохион байгуулсан юм.

Сургалтын эхний өдрийн үдээс өмнө, Сэлэнгэ аймгийн зүгээс арга зүй түгээн дэлгэрүүлэх тогтолцоо, менежментийн талаархи туршлагаасаа хуваалцсан юм. Үдээс хойш нь оролцогчид 4 судлагдахууны (“Хүн орчин”, “Хүн байгаль”, “Төсөлт ажил”, “Суурь Математик”) багт хуваагдан ажиллаж, хичээлийн судалгааны талаар судалсан.

Сургалтын 2 дахь өдөр, оролцогчид хичээл заах багш, хүүхэд, ажиглагч багшийн дүрд тоглон, судалгаат хичээл зохион байгуулж туршсан. Оролцогчдын ихэнхи нь сургуулийн захирал байсан хэдий ч, захирлууд туршилтын хичээлээр дамжуулан хичээлийн судалгаанд оролцож үзэн

хичээлийн бэлтгэл судалгаа, хичээлийн бэлтгэл, хичээл зохион байгуулах арга зэрэг маш чухал гэсэн санал хэлж байлаа. Түүнчлэн, хичээлийн явцад сурагчдад бодож тунгаах цаг гаргаж өгөх, дэвтэрт хөглөх арга зэрэг нарийн тодорхой зүйлүүдэд ч анхаарахаас гадна багш нартаа хэрхэн зөвлөгөө өгөх тухай ч санал бодлоо солилцсон.

Өнөөг хүртэл төслийн хүрээнд загвар бус аймагт зориулсан сургалт, мониторингийн үйл ажиллагааг ч зохион байгуулж ирсэн. Энэ удаад Орхон, Дорноговь аймагт зориулсан сургалтыг зохион байгуулснаар нийт 21 аймгаас ямар нэг байдлаар шууд үйл ажиллагаа зохион байгуулсан аймгийн тоо 15-д хүрсэн юм.

Захирал болон сургалтын менежерүүд хэлэлцүүлэг хийж буй байдал



2013 оны 1 сарын 28-наас 2 сарын 1-нд МУИС дээр 5 өдрийн турш БМДИ, БХ, НБГ-аас ирүүлсэн оролцогчид болон мэргэжлийн багийн залуу гишүүдэд зориулсан хэлэлцүүлэг сургалтыг Японы мэргэжилтнүүд зохион явууллаа.

Бага ангийн математикийн хэлэлцүүлэг сургалтад, тус төслийн арга зүй түгээн дэлгэрүүлэх мэргэжилтэн Х.Такахата сургагч багшаар ажиллан, БГД-ийн “Сэтгэмж” ЦС-д томилогдон ажиллаж буй Японы залуу сайн дурын гишүүн К.Нишиүчигийн тусламжтайгаар сургалтад ороцлогчид “Бутархай тооны нэмэх, хасах үйлдэл”, “Трапецийн талбайг олох нь” сэдвээр хичээлийн бэлтгэл судалгаанд оролцлоо.

Хэлэлцүүлэг сургалтын эхний өдөр хичээлийн бэлтгэл судалгаа гэж чухам юу болох тухай танилцуулсны дараа, уг сургалтаар заах “Бутархай тооны нэмэх, хасах үйлдэл”, “Трапецийн талбайг олох нь” сэдвийг Монголын сурах бичгүүдэд хэрхэн тусгасан байдаг тухай тодруулав. Сургалтын 2 дахь өдөр “Бутархай тооны нэмэх, хасах үйлдэл” болон “Трапецийн талбайг олох нь” сэдвийг Монгол хүүхдүүд (1) Сайн ойлгож чаддаг уу?, (2) Хэрэв алдаа бүдрэлт гардаг бол шалтгаан нь юунд байдаг гэж зэргээр харилцан ярилцсан. Сургалтын 3-4 дэх өдөр оролцогчид эдгээр нэгж хичээлтэй холбоотой ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулсан бөгөөд, боловсруулсан хичээлийн хөтөлбөрт 5 дахь өдөр нь мэргэжилтэн Х.Такахата үнэлэлт дүгнэлт өгсөн юм. (Хэлэлцүүлэг сургалтын агуулгын дэлгэрэнгүйг <http://hicheeliin-sudalгаа.mn-ээс> үзнэ үү.)

Зөвлөмж: Хичээлийн бэлтгэл судалгаа хийхэд дараахи зүйлүүд чухлаар тавигдана.

- 1) Сурагчдад заах агуулга өмнө судалсан болон дараа судлах зүйлтэй нь хэрхэн холбогдож буйг тодорхойлох.
- 2) Судлах агуулгыг сурагчдад заахдаа, ямар материал ашиглавал тохиромжтой болохыг туршиж үзэх. Жишээлбэл, бутархай тооны тухай ойлголтыг сэдэлжүүлэхдээ “Бялуу г.м бодит зүйл ашиглах” ба “Метр ашиглах” хоёрын аль нь тохиромжтойг бодож үзэх хэрэгтэй. Мөн, заах гэж буй бутархай тооны тухай,



Зөвлөх багш Такахата оролцогчдод арга зүйн зөвлөмж өгч байгаа нь

“1/3” ба “1/4” -ийн алийг нь эхэлж заавал тохиромжтой үз гэдгийг бодолцох.

- 3) Сурагч аливааг өөрөө бодож сэтгэхийн үндэс суурь болохуйц зүйлийг багш сайтар бодож олох хэрэгтэй. Энэ нь сурагчдад өмнөө тулгамдсан асуудлыг өөрсдөө шийдвэрлэх боломжийг олгодог. Нөгөө талаар хичээлийн цаг 40-хөн минутаар хязгаарлагддаг учир гол сэдэвтэй бараг холбоогүй асуудалд цагаа дэмий үрэх хэрэггүй.

Сурагчид арвин зүйл сурч мэдэхэд хичээлийн бэлтгэл судалгаа зайлшгүй чухал юм. Тиймээс, хичээлийн судалгаагаар дамжуулан хичээлийн бэлтгэл судалгааг дахин давтан хийжгээ. Өөрөөр хэлбэл, хичээлийн бэлтгэл судалгаанд тулгуурлан үр өгөөжтэй хичээлийн судалгааг зохион байгуулцгаая.



Байгалийн ухааны хэлэлцүүлэг сургалтын зорилгыг 1-рт хичээлийн бэлтгэл судалгаа (кёозай кэнкюу), түүнчлэн кёозай боловсруулах, түгээн дэлгэрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах замаар сургалтын чанар, ахицыг дээшлүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах, 2-рт Хичээлийн бэлтгэл судалгааны дугуйлан байгуулах явдал хэмээн тодорхойлсон бөгөөд “Сонирхолтой бөгөөд хялбар сорил туршилт”-ын тухай болон багш нар хичээлдээ ашиглаж буй сорил туршилтуудаа танилцуулснаас гадна интернетээр янз бүрийн туршилтын дүрс бичлэг үзэх боломжтой цахим хуудас зэргийг танилцуулсан. Мөн, Ш.Мацүүра багшийн судалгааны ажлын өрөөтэй скайп мессэнжер ашиглан дүрсээр шууд холбогдож, сорил туршилтаа харилцан харуулах байдлаар хэлэлцүүлэг сургалтыг зохион байгуулж байлаа.

Туршилтад голчлон “Агаар” сэдвээр хийн бөмбөлөг болон хуванцар сав ашиглаж, агаар хэрхэн оршдог болох, агаарын эсэргүүцэл болон агаарын агшилт, тэлэлтийн

талаар ойлгуулах боломжтой туршилтын хэрэглэгдэхүүн бэлтгэсэн. Оролцогчдын авчирсан цаасан хайрцагт нүх гарган хайрцага хоёр талаас нь шахахад хайрцаг дахь нүхээр агаар гадагшилж буйг харуулах, үүгээр дамжуулан агаарын урсгалын шинж чанарыг энгийн нүдээр харж ойлгуулахуйц туршилтын хэрэглэгдэхүүнийг бүтээсэн юм.

Энэ мэтчилэн, хялбар сорил туршилтын талаархи мэдлэгээ улам олон багш нартай хуваалцах боломжийг бий болгох үүднээс туршилтын явцыг дүрсжүүлэн “YouTube” болон төслийн цахим хуудсанд тавих аргачлалыг ч танилцуулсан.

Цаашид ийм хэлэлцүүлэг сургалтыг санаачлагатайгаар тогтмол зохион байгуулж, хичээлийн бэлтгэл судалгаа, багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглүүлэн ажиллах нь хүүхэд багачуудын боловсролд үр дүнгээ өгөх болно. Интернетийг идэвхитэй ашиглах нь цаашид хичээлийн бэлтгэл судалгаагаа гүнзгийрүүлэх нэг сайн арга болно.



Хялбар туршилт танилцуулж буй байдал

Сорил туршилтын цахим хуудсууд:

- WAO Science Navi** <http://science.wao.ne.jp/experiment/>
- Discover Science (NHK)** <http://www.daikagaku.jp>
- Phet simulations** <http://phet.colorado.edu>
- MIT OCW** <http://ocw.mit.edu/index.htm>
- YouTube** <http://www.youtube.com/>
- Skype** (a free internet video communication) <http://www.skype.com/intl/en/get-skype/>

**ТӨСЛИЙН ЭЦСИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН
СУДАЛГАА**

Төслийн загвар 14 сургууль, загвар бус аймаг (Хөвсгөл, Увс), дүүргийн (ЧД) 6 сургууль дээр төсөл эхлэх үеийн (2010 оны 9 сар) болон 1 жил хагасын хугацаа өнгөрсөн 2012 оны 4 сарын байдлаархи өөрчлөлтийг тодорхойлох зорилгоор эцсийн төлөв байдлын судалгааг зохион явууллаа.

Судалгааны дүнд загвар сургуулийн багш нарт дараахи гол өөрчлөлтүүд гарчээ.

- Төслийн өмнөх шатанд боловсруулан нийт багш нарын хүртээл болгосон зөвлөмжийг ашиглахад дөхөм болсон.
- Бусад багш нарын хичээлд ажиглалт хийх, эсвэл өөрийн хичээлийг бусдад үзүүлэх зэрэг боломжууд нэмэгдсэн.
- Хамт ажилладаг багш нартайгаа хамтран хичээлээ төлөвлөлтөө ярилцах боломж нэмэгдсэн.
- Сургуулийн удирдлага, багш нар арга зүйн шинэчлэлийн талаар нэгдсэн ойлголттой болсон гэж үзэх багш нар олширсон.

Мөн, загвар аймгийн хувьд БСГ-ын мэргэжилтнүүд сургуулиудад илүү олон очиж ажиллах болжээ.

Аймгийн БСГ, сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн хувьд цаашдын тулгамдсан асуудал нь туршлага багатай багш нарын арга зүйг хэрхэн сайжруулах вэ, багш бэлтгэх их дээд сургууль төгсөн шинээр ажилд орж буй багш нарыг хэрхэн сургах вэ гэдэг асуудал байдаг байна.

Судалгааг загвар аймаг, дүүрэг сонгосноос хойш дөнгөж 1 жил хагасын дараа зохион байгуулсан бөгөөд хэдийгээр ахархан хугацаа өнгөрсөн ч аймгуудын БСГ болон сургуулийн удирдлага, багш нарын ойлголт, үйл ажиллагаанд томоохон өөрчлөлтүүд гарсан байна.

Загвар бус аймаг, дүүргээс судалгаанд хамрагдсан сургуулиудын хувьд ч бараг загвар сургуулиудтай ижил хандлага ажиглагдаж байсан бөгөөд асуулгад өгсөн хариултууд бага зэрэг харилцан адилгүй байв. Загвар бус аймаг, дүүргээс судалгаанд хамрагдсан сургуулиуд төслийн бүсчилсэн сургалтад (2011, 2012 оны 11 сар) хамрагдаж байсан бөгөөд бусад аймгуудын нэгэн адил зөвхөн өөрийн аймагтаа зориулсан сургалт авмаар байсан гэдгээ ч гэсэн илэрхийлж байлаа.

Эцсийн төлөв байдлын судалгааны тайланг загвар аймаг, дүүргийн БСГ/БХ, загвар 14 сургууль, загвар бус аймаг, дүүргээс судалгаанд хамрагдсан 6 сургуульд хүргүүлсэн. Судалгаа явуулахад хамтран ажилласан та бүхэндээ гүнээ талархал илэрхийлье. Эцэст нь, цаашид өөрийн сургууль, түүнчлэн аймгийнхаа боловсрол сургалтын үйл ажиллагаанд энэхүү судалгааны дүнг тусган ажиллахыг та бүхнээс хүсье.

ТӨСЛИЙГ 6 САРЫН ХУГАЦААГААР СУНГАВ

2012 оны 5 сард “Боловсролын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсноор багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцоонд томоохон өөрчлөлт гарсан. Тус төсөл нь анх 2013 оны 2 сарын сүүл үе хүртэл хэрэгжихээр төлөвлөгдсөн байсан хэдий ч төсөл дууссаны дараахи тогтвортой байдлыг хангах үүднээс 2013 оны 8 сарын сүүл хүртэл үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхээр боллоо.

Өнөөг хүртэл төслийн хүрээнд хэрэгжүүлж ирсэн хичээлийн судалгаагаар дамжуулан багшлахуйн арга зүйн шинэчлэх аргачлалыг шинээр байгуулагдсан БМДИ-ийн хамт олонд дамжуулан үлдээх ажил үлдэж буй хугацааны гол үйл ажиллагаа болох юм.

6 сарын хугацаанд хэрэгжүүлэх гол ажлуудыг хүснэгтэд үзүүлэв.

Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Зорилго
Загвар аймаг, дүүргийн хичээлийн судалгааны мониторинг	Булган: 3 сарын 24-29 Завхан: 4 сарын 8-15 СХД: 4 сарын 15-наас	Загвар сургуулийн хичээлийн судалгааг ажиглан, мониторингийн аргачлалыг БМДИ-д танилцуулах.
Математик, Байгалийн ухааны хичээлийн судалгааны хэлэлцүүлэг сургалт	3-5 сард 1 удаа	Бие даан судалгаа хийх зохион байгуулалтыг буй болгох, /Дор дурьдах/ хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний хурлын суурийг тавих.
Сургалтын модуль, хичээл ажиглалтын хуудсыг танилцуулах	5 сарын эхэнд 2 хоног	Төслийн хүрээнд боловсруулсан сургалтын модуль, хичээл ажиглалтын хуудсыг танилцуулах.
Япон дахь сургалт	1. Японы боловсролын тогтолцоо: 5 сард 2 долоо хоног 2. Багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо: 5 сарын сүүлчээс 2 долоо хоног	1. Японы боловсролын тогтолцооны тухай танилцуулах замаар Монголын багш нарыг чанаржуулахад чиглэсэн санаа өгөх. 2. Багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцооны талаар танилцуулан, 2013 оны 9 сараас хойшхи багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад санаа өгөх.
Багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн уулзалт зохион байгуулах	7 сарын эхэнд /Наадмын өмнө/ 2 хоног	2013 оны 9 сараас хойшхи Багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах.
Хичээл судалгааны эрдэм шинжилгээний анхдугаар удаагийн хурал зохион байгуулах	8 сарын дундуур 2 хоног	Загвар сургуулийн хичээлийн судалгааны туршлагыг хуваалцан, Монгол Улс дахь хичээлийн судалгаатай холбоотой судалгааг гүнзгийрүүлэх.
Мэдлэг мэдээллээ хуваалцах уулзалт зохион байгуулах	8 сарын дундуур 1 хоног	Багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг болон Хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний хурлын үр дүнг танилцуулах.

Төслийн багийн холбоо барих хаяг:

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Энхтайваны
Өргөн Чөлөө 10, Багш Хөгжлийн Ордон,
4 давхар, 406 тоот

Утас/Факс: 976-7012-0503, 9890-0323

Төслийн багийн Е-мэйл хаяг: <jicacctm@gmail.com>

Төслийн вебсайт: <http://hicheeliin-sudalгаа.mn/>

Вебсайт: <http://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/004/index.ht>

